МОНГОЛ УЛС, СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЕРӨӨ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 17 өдөр | Дугаар 40 | Тавин

Ерөө сумын 2022 оны хөгжлийн
жилийн төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.1-ийн "д" дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ерөө сумын 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Ерөө сумын 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Сэргэлэн/, багийн засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА Э.АРИУНБАТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын
17-ны өдрийн 40 тоот тогтоолын хавсралт

# ЕРӨӨ СУМЫГ ХӨГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Суурь түвшин | Хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| **1. НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Иргэдийн эрүүл энх, аюулгүй амьдрах, сурах, хөдөлмөрлөх боломжид суурилан нийгмийн баталгааг бий болгоно.** | | | | | | |
| **1.1 Эрүүл мэндийн бодлого** | | | | | | |
| **Эрүүл мэндийн бодлогыг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| **1** | СЗДҮАХ 2.2 | Эрүүл мэндийн салбарын “Хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулж”, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэн иргэдэд хүрч үйлчлэх боломжийг хангана. | Хүний нөөцийн хүрэлцээ муу. | Хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгаалал сайжирч иргэдэд хүрч үйлчлэх Боломжийг хангасан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЭМТөв |
| **2** | СЗДҮАХ 2.3 | “Эрүүл хүүхэд Ерөөгийн ирээдүй" уриан дор хүүхэд багачуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл өсч бойжих нөхцөлийг бүрдүүлнэ. | Ковид-19 цар тахлын улмаас зохион байгуулаагүй | Хүүхэд бүрийг үзлэгт хамруулсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй | ЭМТөв |
| **3** | СЗДҮАХ 2.4 | Ерөө, Бугант тосгоны Эрүүл мэндийн төвүүдийн “Барилгын өргөтгөлийн ажил”-ыг холбогдох | Одоогийн ашиглаж буй барилга өрөө, тасалгааны | Өргөтгөлийн ажлыг хийсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар ЭМТөв |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ. | хүрэлцээ муу. | | | |
| **4** | АЗДҮАХ 2.1.1, СЗДҮАХ 2.5 | Эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж /УВЧ аппарат, Нярайн шарлалт хэмжих багаж аппаратын хамт, Бугант Эхо аппарат/ үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна | Одоогоор хуучин УВЧ аппаратыг ашиглаж байгаа, Нярайн шарлалт хэмжих багаж аппаратын хамт байхгүй. | УВЧ аппарат, Нярайн шарлалт хэмжих багаж аппараттай болсон байна. | Төсвийн хөрөнгөөр | Аймгийн Эрүүл мэндийн газар, Ерөө ЭМТөв |
| **5** | СЗДҮАХ 2.6 | Хөдөөгийн өрх, малчдад жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж ажиллана. | Ковид-19 цар тахлаас хамааран төлөвлөсөн ажил хэрэгжээгүй. | Сумын төвөөс алслагдсан хэсгийн айл өрхийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэсэн байна. . | Хөрөнгө шаардагдахгүй. | ЭМТөв |
| **6** | СЗДҮАХ 2.4 | Сумын ЭМТөвийн их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ. | Одоогийн ЭМТөвийн барилгад их засвар хийгдэж байгаагүй. | Их засварын ажил хийгдэж иргэд ая тухтай орчинд эрүүл мэндийн үйлчилгээг хүртэнэ. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар, ЭМТ |
| **7** | Алсын хараа-2050 2.2.8, ЗГҮАХ 2.2.1, МУХҮЧ 2.2.2 | Цар тахлын үеийн бэлэн байдал, эм, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, бамбарын нөөц бүрдүүлэлт, тоног төхөөрөмж, дайчлагдан ажиллах хүний нөөц, хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлж ажиллана. | Хүний нөөц хүрэлцээгүй, дутагдалтай байсан. | Шаардлагатай хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдэж хариу арга хэмжээ авсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар, ЭМТ |
| | | | Ковид-19 цар | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **8** | СЗДҮАХ 2.13 | Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдыг урамшуулан дэмжиж ажиллана. | тахлын улмаас эмч, эмнэлгийн ажилчид онцгой нөхцөлд ажил үүргээ гүйцэтгэсэн. | Ажлын гүйцэтгэлийг үнэлж үр дүнг тооцсон байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар, ЭМТ |
| **9** | | Бугант ЭМТ-ийн хуучин барилгыг актлуулах | Ашиглах боломжгүй барилга байна. | ЭМТөвийн гадна тохижилт сайжирч, газрыг дахин төлөвлөлтөнд оруулж ашиглана. | Хөрөнгө шаардагдахгүй. | Захирагчийн алба, ЭМТөв |
| **1.2 Боловсролын бодлого** | | | | | | |
| **Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| **1** | МУТЖҮЧ 2.1.7, ЗГҮАХ 2.3.8, САХТЖҮЧ 2.1.3, САЗДҮАХ 2.2.4, СЗДҮАХ 1.4 | Сум, тосгоны сургууль цэцэрлэгийн “Багш хөгжлийн төв”-үүдийг шаардлагатай техник хэрэглэгдэхүүнээр хангаж багш нарыг ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэн “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. | Ухаалаг самбар, зөөврийн компьютер, өнгөт принтер зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжүүд хүрэлцээгүй. | Шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдаж багш хөгжсөн байна. | Төсвийн хөрөнгөөр | Аймгийн БСГазар, ЕБС, Цэцэрлэг |
| **2** | АЗДҮАХ 2.1.5, СЗДҮАХ 1.7 | Бугант тосгоны ЕБСургуулийн их засварын ажлыг холбогдох байгууллагад уламжилна. | 60 жилийн насжилттай барилгад үйл ажиллагаа явуулж байна. | Барилгын их засварын ажлыг холбогдох шатанд уламжилж шийдвэрлүүлсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | Захирагчийн алба<br>Бугант ЕБС |
| **3** | АЗДҮАХ 2.1.5, СЗДҮАХ | Хүн амын хэтийн төлөв, шилжилт хөдөлгөөн, хүүхдийн ердийн өсөлтийг харгалзан бодит | ЕБСургуулийн дотуур байранд 60 хүүхэд байрладаг ба | Дотуур байрны асуудлыг холбогдох шатанд уламжилж | Хөрөнгө шаардагдахгүй. | ЕБСургууль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1.8 | хэрэгцээнд “150 хүүхдийн дотуур байртай”-тай болох асуудлыг холбогдох шатанд уламжилна. | нийт хамрагдвал зохих хүүхдүүдийг бүрэн хамруулах боломжгүй. | шийдвэрлүүлсэн байна. | | |
| **4** | МУТЖҮЧ 2.1.2, ЗГҮАХ 2.3.3, САХТЖҮЧ 2.1.2, АЗДҮАХ 2.2.4, СЗДҮАХ 1.9 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд хамруулж, хөгжлийг дэмжих зорилгоор “Тусгай танхим”-ыг шинээр байгуулж сурч хөгжих боломжийг бүрдүүлнэ. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан “Тусгай танхим” байхгүй. | “Тусгай танхим”-ыг байгуулж хүүхэд бүр сурч хөгжих боломжоор хангасан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЕБСургууль |
| **5** | МУТХҮЧ 2.1.10, АЗДҮАХ 2.2.11, СЗДҮАХ 1.11 | Сум, тосгонд мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлж “Цахим сургалтын орчныг бүрдүүлэх” зорилгоор шаардлагатай техник хэрэгслүүдийг шинэчилж, цахим сургалтанд эцэг эхийн оролцоог хангаж багш нартай хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ. | Шаардлагатай техник хэрэгслийг шинэчилж сургалтын орчинг бүрдүүлэх шаардлагатай. | Багш, сурагч, эцэг эхийн тэгш оролцоо хангагдсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЕБСургууль |
| **6** | СЗДҮАХ 1.12 | Төгсөх ангийн сурагчдын дунд “Мэргэжил сонголт” арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж, мэргэжлээ сонгоход нь арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч, ажлын байртай танилцах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | Ковид-19 цар тахлаас хамааран арга хэмжээ зохион байгуулаагүй. | Холбогдох хөтөлбөрийг боловсруулж арга хэмжээг зохион байгуулсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар, ЕБСургууль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **7** | МУТЖҮЧ 2.1.7, ЗГҮАХ 2.3.8, АЗДҮАХ 2.2.6, СЗДҮАХ 1.12 | Насан туршийн боловсролын “Сургалтын орчин”-г сайжруулна. | Сургалтын орчин бүрдээгүй. | Шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангаж сургалтын орчинг сайжруулсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар, ЕБСургууль |
| **8** | СЗДҮАХ 1.16 | Сумын төвөөс алслагдсан өрхүүдийн хүүхдүүдийг зөөвөрлөх “Сургуулийн автобус”-ыг ажиллуулж хүүхдүүд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлнэ. | Сумын төвөөс алслагдсан хэсгийн хүүхэд, багачуудыг зөөх унаагүй | Шаардлагатай унаа, тээврийн хэрэгслээр хангасан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **9** | СЗДҮАХ 1.20 | Сум, тосгоны “Сургууль, цэцэрлэгийн орчны нөхцөлийг сайжруулах”-аар хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ байршуулж гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ. | Одоогоор замын тэмдэг тэмдэглэгээ хангалтгүй. | Шаардлагатай зам талбайд тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийг байгуулсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **10** | СЗДҮАХ 1.25 | Багш, суралцагчийн хөгжлийг дэмжиж элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан сурагч, бэлтгэсэн багш, улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн мэргэжлийн хичээлийн багшийг урамшуулж тэтгэлэг олгоно. | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | Багш, суралцагчдын амжилтыг үнэлсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар ЕБСургууль |
| | | Жилдээ орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр | | Оюутан, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **11** | СЗДҮАХ 1.24, 1.25 | суралцаж буй 10-аас дээш оюутны сургалтын төлбөрт зохих дэмжлэгийг үзүүлж их, дээд сургууль төгсөөд, орон нутагтаа ажиллах гэрээг байгуулан хамтарч ажиллана. | Уг арга хэмжээ нь сүүлийн жилүүдэд хэрэгжээгүй. | суралцагчдад зохих төлбөрийн дэмжлэгийг үзүүлсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар ААНэгж |
| **12** | СЗДҮАХ 1.27 | Сургуулийн суралцагчдад хөдөлмөрийн дадлага туршлага олгох байгалийн ухааны хичээлийн туршилт хийх зориулалтын 2 га туршлагын талбай, ногооны газартай болгоно. | Туршилт хийх зориулалтын талбай байхгүй. | Сурагчид хөдөлмөрийн дадлага, туршлага эзэмшсэн байна. Байгууллага дотоодын хүнсний хэрэглээгээ хангах боломжтой болсон байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар ЕБСургууль |
| **13** | | Бугант 3-р баг, 2-р цэцэрлэгийн 60 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлнэ. | Хугацаа болоогүй байгаа. | Ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн байна. | ААНэгжийн хандиваар | ИТХурал ЗДТГазар 2-р цэцэрлэг |
| **14** | СЗДҮАХ 1.23 | Ерөө сумын хуучин сургуулийг МСҮТ болгох асуудлыг холбогдох шатанд уламжилна. | Одоогоор ЕБСургуулийн сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа. Шинэ сургууль 2022 оны 2-р сард ашиглалтад орно. | Орон нутгийн хэмжээнд МСҮТөвтэй болсон байна. | ААНэгжийн хөрөнгөөр | ИТХурал ЗДТГазар БТЕГ ХХК |
| **1.3 Соёл, урлагийн бодлого** | | | | | | |
| **Үндэсний өв соёлыг хөгжүүлэх, сурталчлах, соёл урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| | | | 60 жилийн | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | СЗДҮАХ 3.1 | Сумандаа 400 хүний суудалтай шинэ соёлын төвийн ажлыг эхлүүлэх | насжилттай барилга байгууламжид үйл ажиллагаа явуулж байгаа. Мэргэжлийн хяналтаас холбогдох дүгнэлтийг гаргасан. | Шинэ Соёлын төвийн барилгын ажил эхэлсэн байна. | Улсын төсвийн хөрөнгөөр | Соёлын төв |
| **2** | СЗДҮАХ 3.2 | “Бид Сэлэнгийн үр сад”, “Эв модны наадам”, “Алтаргана” зэрэг томоохон урлаг, соёлын арга хэмжээнүүдэд оролцож, хүүхэд залуучууд, уран бүтээлчдийг дэмжиж ажиллана. | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | Уг арга хэмжээнүүдэд заасан хугацаанд оролцсон байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар Соёлын төв |
| **3** | СЗДҮАХ 3.3 | Сум, тосгоны соёлын төвүүдийг Лед дэлгэцээр хангана. | Тухайн хэрэглэгдэхүүн байхгүй. | Орчин үеийн Лед дэлгэцээр хангагдаж иргэдэд соёл урлаг, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг түгээнэ. | Аймгийн төсвийн хөрөнгөөр | Соёлын төв |
| **4** | СЗДҮАХ 3.4 | Сумын номын сангийн уншлагын танхимыг интернетэд холбож компьютер тоног төхөөрөмжөөр хангаж цахим номын сангийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | Одоогоор интернет сүлжээ, цахим орчин бүрдээгүй. | Цахим номын сангийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | Соёлын төв |
| | СЗДҮАХ | Соёлын төвийн “Үндэсний | Одоогийн | Шинэ хөгжил, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **5** | 3.5 | хөгжим"-ийг шинэчилнэ. /Ёочин, шанз, ятга, морин хуур, хуучир, лимбэ гэх мэт/ | хөгжим, хэрэглэгдэхүүн хуучирч муудсан. | хэрэглэгдэхүүнээр хангагдсан байна. | Аймгийн төсвийн хөрөнгөөр | Соёлын төв |
| **6** | Алсын хараа-2050 1.2.1, ЗГҮАХ 2.3.4, МУХҮЧ 1.2.1, 2.1.3,И2.1.20, СЗДҮАХ 3.8 | Сумын орон нутаг судлах "Музейн үзмэр"-ийг баяжуулж нутаг орныхоо онцлог, түүх, соёлын онцлогийг сурталчлахын зэрэгцээ "Өв соёлын өргөө"-тэй болж монгол ахуй соёл, зан үйлийг хүүхэд багачууд, залуучууд, иргэдэд сурталчлан таниулна. | Орон нутаг сурталчлах танхимд өв соёлын өргөө байхгүй. | Өв соёлын иж бүрэн өргөөтэй болж монгол ахуй, соёл, зан үйлийг сурталчлан ажилласан байна. | Иргэн, ААНэгжийн хөрөнгөөр | Соёлын төв |
| **7** | СЗДҮАХ 3.12 | Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулж, "Цахим соёл"-ыг түгээн дэлгэрүүлнэ. | Бүх төрлийн донтолтоос үүдсэн гэмт хэрэг зөрчил ихээр гарч байна. | Орон нутгийнхаа хэмжээнд "Цахим соёл"-ыг түгээсэн байна. | Өөрсдийн нөөц бололцоогоор | Соёлын төв |
| **8** | СЗДҮАХ 3.13 | Соёл урлагаар аймаг, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан иргэд, хүүхэд багачуудыг урамшуулна. | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | Соёл урлагаар амжилт гаргасан иргэд, хүүхэд багачуудыг урамшуулсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар Соёлын төв |
| | | | Засгийн газрын | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **9** | СЗДҮАХ 3.17 | Малчин өрхүүдэд соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна. | 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | Хөдөөгийн иргэдийг соёл урлаг, спортын үйлчилгээгээр хангасан байна. | Өөрсдийн нөөц бололцоогоор | Соёлын төв |
| **11** | | Мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор сум орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах ажилтныг мэргэжлээрээ суралцахад нь дэмжлэг үзүүлнэ. | Бүжгийн багш мэргэжлийн бус сурах хүсэлтэй . | Мэргэжилтэй боловсон хүчний тоо нэмэгдсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | Соёлын төв |
| **12** | | Соёлын төвийн ажилчдыг зөөврийн компьютер, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах нөхцөл боломжоор хангана. | Одоогийн хэрэглэж байгаа техник, тоног төхөөрөмж хүрэлцээ муу. | Албан хаагчид техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | Төсвийн хөрөнгөөр | Соёлын төв |
| **1.4 Биеийн тамир, спортын бодлого** | | | | | | |
| **Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгоно.** | | | | | | |
| **1** | СЗДҮАХ 3.13 | Тив дэлхийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон тамирчдыг урамшуулж дэмжиж ажиллана. | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | Тив дэлхийн болон улсын аварга төрөх боломж бүрдсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар Спорт цогцолбор |
| **2** | СЗДҮАХ 3.15 | “Шинэ давалгаа Ерөөгийн хөгжилд” спортын наадмыг зохион | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл | Орон нутгийн харьяалалтай иргэдийн хамтын оролцоо, үйл | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар ТББайгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулна. | байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | ажиллагааг хангасан байна. | | |
| **3** | СЗДҮАХ 3.16 | Спортын холбоо клубуудын үйл ажиллагааг дэмжиж, хамтран тэмцээн уралдааныг шат дараалалтайгаар зохион байгуулж Ерөө сумын үндэсний болон бусад спортын шигшээ баг тамирчдыг бэлдэхэд бодлогоор дэмжинэ. | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | Спортын холбоо, клубуудын үйл ажиллагааг сэргэсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар Спорт цогцолбор |
| **4** | СЗДҮАХ 3.18 | Сумандаа аймаг, бүсийн чанартай тэмцээн уралдааныг зохион байгуулна. | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | Аймаг, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг зохион байгуулсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар Спорт цогцолбор |
| **5** | АЗДҮАХ 2.3.10 | Ахмад тамирчдад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын уралдаан тэмцээнийг төрөлжүүлэн зохион байгуулна. | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | Төрөлжүүлсэн спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулсан. | Хандив тусламжаар | Спорт цогцолбор ААНэгж |
| **6** | Алсын хараа-2050 3.5.4, ЗГҮАХ 2.2.1, МУХҮЧ 3.5.3 | “ЗОХИСТОЙ ХӨДӨЛГӨӨН-ЭРҮҮЛ МЭНД” аяныг өрнүүлж, спорт цогцолборыг түшиглэн нийтийн биеийн | Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй | Нийтийн биеийн тамираар хичээллэгчдийн тоо нэмэгдсэн байна. | Өөрийн хөрөнгөөр | Спорт цогцолбор |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тамираар хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ. | байсан. | | | |
| **7** | Алсын хараа-2050 3.5.5 | Спорт цогцолборын гадна засвар, тохижилтын ажлыг хийнэ. | Гадна засварын ажил огт хийгдээгүй. | Спорт цогцолборын гадна тохижилт сайжирсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Спорт цогцолбор |
| **8** | Алсын хараа-2050 3.5.13 | Багш, дасгалжуулагчдыг чадавхжуулах сургалтанд хамруулна. | Одоогоор холбогдох албан хаагчид сургалтанд хамрагдаагүй байна. | Багш, дасгалжуулагч чадавхжсан байна. | Өөрийн хөрөнгөөр | Спорт цогцолбор |
| **9** | Алсын хараа-2050 3.5.5 | Спорт цогцолборын бялдаржуулах танхимын тоног төхөөрөмжийг шинэчилнэ. | Тоног төхөөрөмжүүдийн төрөл цөөн, хуучирч муудсан. | Шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчилж тоо хэмжээ нэмэгдсэн байна. | Хандив тусламжаар | Спорт цогцолбор |
| **10** | | Бугант 3-р багийн хэмжээнд Спорт заал барих ажлыг эхлүүлсэн байна. | Багийн хэмжээнд тогтсон Спорт заал байхгүй. | Спорт заал барих ажил эхэлсэн байна. | ААНэгжийн хөрөнгөөр | ИТХурал ЗДТГазар Захирагчийн алба |
| **1.5 Гэр бүл, хүүхэд залуучуудын бодлого** | | | | | | |
| **Гэр бүлд ээлтэй бодлогыг хэрэгжүүлж амьдралын арга ухаанд сургах хөдөлмөрч, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлнэ.** | | | | | | |
| **1** | Алсын хараа-2050 2.2.10, ЗГҮАХ 2.1.13, МУХҮЧ 2.2.8, СЗДҮАХ 4.5 | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангаж нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаанд хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | Сүүлийн жилүүдэд арга хэмжээ зохион байгуулаагүй. | Ахмад настан, ХБИргэдийг нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаанд хамруулсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар ЭМТөв |
| **2** | СЗДҮАХ 4.6 | Сумын хэмжээний төр, төсвийн байгууллагууд, үйлчилгээний газруудад ахмад настан, жирэмсэн, | Энэ төрлийн үйлчилгээ, соёл | Тухайн чиглэлийн үйлчилгээний соёл хэвшсэн | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар Албан байгууллагууд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дараалал харгалзахгүйгээр үйлчлүүлэх "Үйлчилгээний соёл"-ыг нэвтрүүлнэ. | дутмаг. | байна. | | |
| **3** | СЗДҮАХ 4.7 | Шинэ залуу гэр бүл, болон зорилтот бүлгийн иргэд, төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг "Орон сууцжуулах" бодлогыг хэрэгжүүлэн ажиллана. | Сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа хэрэгжээгүй. | Орон сууцжуулах бодлогыг хэрэгжүүлсэн байна. | Хандив тусламжаар | ИТХурал ЗДТГазар ААНэгж |
| **4** | Алсын хараа-2050 2.3.2, 2.3.11, ЗГҮАХ 2.5.8, МУХҮЧ 2.3.1, СЗДҮАХ 4.8 | "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, "Түр хамгаалах байр"-ыг байгуулна. | Түр хамгаалах байр байхгүй. | Түр хамгаалсан байрыг байгуулсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **5** | Алсын хараа-2050 2.3.2, 2.3.11, ЗГҮАХ 2.5.8, МУХҮЧ 2.3.1, СЗДҮАХ 4.9 | Хүүхэд, гэр бүлд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна. | Орон нутгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл их байна. | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлсэн, зохих арга хэмжээг цаг алдалгүй авч, гэмт хэрэг зөрчлийн тоо буурсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **6** | СЗДҮАХ 4.9 | Архины хамааралтай өрх, иргэнд чиглэсэн арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлнэ. | Архины хамааралтай иргэд, гэмт хэрэг зөрчлийн тоо их байна. | Архины хамааралтай иргэдийн тоо буурсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар Цагдаагийн хэсэг ГХУССЗ |
| | | "Тэргүүний өрхийн аж ахуй, "Бүтээлч айл өрх", | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, | Айл өрх, сум, орон нутгийн өнгө | Орон нутгийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | СЗДҮАХ 4.10 | “Соёлч өрх”, -ийг шалгаруулж туршлагыг нь түгээн дэлгэрүүлж, иргэд бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлнэ. | Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй. | үзэмж нэмэгдсэн, амьдрах таатай орчин бүрдсэн байна. | төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| 8 | | ТББайгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллах | ТББайгууллагууд байнгын үйл ажиллагаа явуулах байртай байх шаардлагатай. | ТББайгууллагууд өөрийн гэсэн байртай болсон байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар ТББайгууллагууд |
| 9 | СЗДҮАХ 2.5 | Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЭМТөвд жилд 10-аас доошгүй иргэнийг Имра аппратаар оношлуулах үзлэгт хамруулна. | Энэ төрлийн арга хэмжээ шаардлагатай байна. | 10-аас доошгүй иргэдийг хамруулсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **1.6 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал** | | | | | | |
| **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 1 | Алсын хараа-2050 2.6.2, ЗГҮАХ 2.5.9, МУХҮЧ 2.6.2, СЗДҮАХ 4.1 | Жил бүр ажилгүй иргэдийн судалгааг үндэслэн орон нутгийн бүтээн байгуулалтын ажлын эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ. | Орон нутгийн хэмжээнд мэргэжил эзэмших боломжгүй. | Жилд 10 иргэнийг хамруулсан байна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | ЗДТГазар |
| 2 | Алсын хараа-2050 2.6.3, МУХҮЧ 2.6.2, СЗДҮАХ 4.2 | Сумын хэмжээнд байгаа мэргэжилтэй боловсон хүчинг ажлын байранд зуучилж, ажилтай, орлоготой болгох зорилгоор “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөрийг | Ажил хайгч иргэдийн 100% ажлын байраар хангах боломжгүй. | Ажилтай, орлоготой өрх, иргэний тоо нэмэгдсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлж ажилгүйдлийг багасгаж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана. | | | | |
| **3** | СЗДҮАХ 4.4 | Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой зорилтот бүлгийн өрхийг “Малжуулах, туслах аж ахуй эрхлэх” нөхцөл боломжоор хангаж амьжиргааны эх үүсвэртэй болгоно. | Зорилтот бүлгийн өрхүүд сангийн эх үүсвэр байхгүй. | Жилд 5 өрхийг хамруулна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | ЗДТГазар |
| **4** | АЗДҮАХ-ийн 2.6.10 СЗДҮАХ-ийн 4.11 | Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн өрхийн амьжиргааг дэмжиж ажиллана. | Нийгмийн халамжийн үйлчилгээнд зорилтот бүлгийн өрхийг бүрэн хамруулах боломжгүй. | Зорилтот бүлгийн өрхийн амьжиргааг дэмжсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | ЗДТГазар |
| **5** | Алсын хараа-2050 3.1.1, СЗДҮАХ 4.12 | Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж сайн дурын даатгалд ХХЭрхлэгч, малчдыг 60 % хамруулна. | Нийгмийн даатгалд хамрагдагсдын тоо хэмжээ хангалтгүй. | Хамрагдалтын тоо хэмжээ нэмэгдсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **6** | Алсын хараа-2050 3.1.1, СЗДҮАХ 4.12 | Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсдын %-ийг нэмэгдүүлж хөдөлмөр эрхэлдэггүй иргэн, ХХЭрхлэгч, малчдыг хамруулна. | Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсдын тоо хэмжээ хангалтгүй. | Хамрагдалтын тоо хэмжээ нэмэгдсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **2. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | |
| **2.1 Мэргэшсэн, ёс зүйтэй, иргэнд ээлтэй төрийн алба** | | | | | | |
| **Чадварлаг, ухаалаг, хүртээмжтэй, нээлттэй засаглалын тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | СЗДҮАХ 1.1 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх , иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх чиглэлээр төрөл бүрийн ажил үйлчилгээг нэвтрүүлж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ***“нийтэд ил тод, нээлттэй, хяналттай болгоно”***. | | Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, тоо хэмжээ нэмэгдсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **2** | СЗДҮАХ 1.2 | Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлж, хариуцлага , үр дүнг тооцох арга хэлбэрийг сайжруулж, мэдлэг, хандлагад суурилсан ***“мэргэшсэн төрийн албан хаагч”***-даар бүрдүүлж ажиллана. | Шатлан дэвшсэн төрийн албан хаагчдын тоо -хариуцлага хүлээсэн албан хаагчдын тоо | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт хангагдана. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **3** | СЗДҮАХ 1.3 | Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй , шуурхай хүргэх, иргэдэд мэдээ мэдээллийг цаг алдалгүй мэдээлэх зорилгоор ***“Цахим Ерөө”*** хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг дээшлүүлнэ. | -Нийт үзүүлсэн үйлчилгээний тоо | Үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **4** | СЗДҮАХ 1.5 | ***“Сумын архив”***-ын байрыг зориулалтын техник, тоног | Зориулалтын техник, тоног төхөөрөмж, | Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төхөөрөмжөөр хангаж , тохижуулна. Нээлттэй үйл ажиллагаа. нэмэх | хэрэглэгдэхүүн, эд хэрэгсэл авч байгаагүй. | нөхцөлийг бүрдүүлж стандартын тоног төхөөрөмжтэй болсон байна. | | |
| **5** | СЗДҮАХ 1.8 | Төрийн албан хаагчдын ажлын арга туршлагыг харилцан солилцох бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлж ажиллана. | Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа зохион байгуулаагүй. | Арга туршлага, ур чадвар нэмэгдсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **6** | СЗДҮАХ 1.9 | Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл , нийгмийн баталгааг эрэлт, хэрэгцээ , нийгмийн шаардлагад нийцүүлэн сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж төр, төсвийн байгууллагын ***"шинэ залуу боловсон хүчнүүдийн нийгмийн асуудал"***-ыг бодлогоор дэмжиж ажиллана. | Сүүлийн жилүүдэд ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй. | Төр, төсвийн байгууллагын ***"шинэ залуу боловсон хүчнүүдийн нийгмийн асуудал"***-ыг бодлогоор дэмжиж ажиллана. | Төсвийн хөрөнгөөр Хандив тусламжаар | ИТХурал ЗДТГазар ААНэгж |
| **7** | МУХҮЧ 5.4.6, МУЗГҮАХ 4.1.8, СЗДҮАХ 2.7 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд ***" Гэрэлт Мэдээллийн самбар"*** шинээр байрлуулан иргэдийг цаг үеийн мэдээ мэдээллээр түргэн шуурхай хангаж ажиллана. | Орон нутгийн хэмжээнд мэдээллийн самбар байхгүй. | Иргэд цаг үеийн мэдээ мэдээллээр хангагдсан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **8** | СЗДҮАХ 5.1 | Газар өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдсон мэдээллийн ил тод байдлыг хангаж, ***"шинээр*** | Шинээр өмчилсөн иргэний тоо | Иргэд газраа өмчилсөн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ***өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж”,*** газрыг эдийн засгийн эргэлтэд оруулна | | | | |
| **9** | СЗДҮАХ 5.2 | Сумын газар эзэмшүүлэх, ашиглуулах “дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд ил болгож”, цахим биржийн үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлнэ. | Зохион байгуулсан дуудлага худалдааны тоо | Дуудлага худалдааны үйл ажиллагаа ил тод болно. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **10** | СЗДҮАХ 1.11 | Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах , нийгмийг хамарсан цар тахлын эрсдэлийг бууруулах зорилгоор шаардлагатай, нөөц хөрөнгийг төвлөрүүлэн төсөвт суулгах, багаж техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслээр албан хаагчдыг хангах ажлыг шат дараатайгаар авч хэрэгжүүлнэ. | Техник, тоног төхөөрөмж, шаардлагатай хэрэглэгдэхүүний нөөц хомс. | Гамшгаас урьдчилан сэргийлж албан хаагчид шаардлагатай тоног, төхөөрөмж, хувцас хэрэгслээр хангагдсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ИТХурал ЗДТГазар |
| **11** | МУХҮЧ 5.4.6, МУЗГҮАХ 4.1.8 | Иргэдийг цаг үеийн бодит мэдээллээр хангах зорилгоор “Ерөөгийн мэдээ” сонинг улирал тутам өрх бүрт хүргэж ажиллана. | Сүүлийн жилүүдэд хэрэгжээгүй. | Өрх, иргэнийг мэдээллээр хангасан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **12** | Алсын хараа-2050 7.2.7 ЗГҮАХ-ийн 4.3.1 | Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад шаардлагатай дэмжлэг туслалцааг | Хамтран ажиллах тухай хүсэлт ирсэн. | Улсын хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил буурсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | МУХҮЧ-ийн 7.2.3 | үзүүлнэ. | | | | |
| **13** | Алсын хараа-2050 1.3.1, МУХҮЧ 1.3.1 | Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрдүүлж, хүүхэд багачууд, иргэдэд эзэмшүүлэн “Үндэсний бичгээрээ уншиж, бичицгээе 2021-2025” аяны хүрээнд арга хэмжээ зохион байгуулна. | Үндэсний бичгийн хэрэглээг таниулан сурталчлах шаардлагатай. | Үндэсний бичгийн хэрэглээний орчин бүрдэж, үндэсний бичгийн мэдлэг, чадвартай иргэдийн тоо нэмэгдэнэ. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **14** | СЗДҮАХ 1.20 | Сумын хэмжээнд айл, өрхүүдийн хашаа хороог шинэчлэх, цэгцлэх ажлыг зохион байгуулж “Гудамж” төсөл, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллана. | Сум, орон нутгийн хэмжээнд шийдвэрлэвэл зохих асуудлын нэг. | Айл, өрхийн хашаа хороо цэгцлэгдэж сум, орон нутгийн өнгө үзэмж сайжирч хөтөлбөр хэрэгжсэн байна. | Төсвийн болон ААНэгжийн дэмжлэгтэйгээр | ИТХурал ЗДТГазар ААНэгжүүд |
| **15** | | Сумын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг хийлгэнэ. | Одоогоор хийгдээгүй байгаа. | Сумын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн. | ААНэгжийн хөрөнгөөр | ЗДТгазар |
| **2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээ** | | | | | | |
| **Хүн, нийгмийн амар тайван байдлыг бэхжүүлнэ.** | | | | | | |
| **1** | СЗДҮАХ 2.9 | Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх , нийгмийн хэв журмыг сахиулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ***“иргэд, олон нийттэй хамтарч ажиллана”***. | Иргэдийн оролцоо муу. | Гэмт хэргийн гаралт буурсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар Цагдаагийн хэсэг ГХУССЗ |
| | | Архидан согтуурахтай тэмцэх хяналт шалгалтыг | Энэ төрлийн гэмт | Гэмт хэргийн | Хөрөнгө | ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **2** | СЗДҮАХ 2.10 | тогтмолжуулж, ***" Архигүй орчин"*** хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдэд энэ талын мэдлэг мэдээллийг олгож хамтарч ажиллана. | хэрэг, зөрчлийн тоо их. | гаралт буурсан байна. | шаардагдахгүй. | Цагдаагийн хэсэг ГХУССЗ |
| **3** | СЗДҮАХ 2.11 | Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор ***" Хамтарсан баг"***-ийн хяналтын үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллана. | Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн тоо их. | Гэмт хэргийн гаралт буурсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар Цагдаагийн хэсэг ГХУССЗ |
| **4** | СЗДҮАХ 2.12 | Хүүхдийг цахим гэмт хэрэг, мэдээллийн халдлага, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулж, энэ талын мэдлэг мэдээллийг эцэг, эх, хүүхдэд байнга өгч , хамтарч ажиллана. | Эцэг эх, хүүхдийн мэдлэг, мэдээлэл дутмаг. | Гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар Цагдаагийн хэсэг ГХУССЗ |
| **5** | СЗДҮАХ 2.13 | Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор " малчдын бүлэг"-тэй хамтарч ажиллана. | Иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа хангалтгүй. | Гэмт хэргийн гаралт буурсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар Цагдаагийн хэсэг ГХУССЗ |
| **6** | СЗДҮАХ 2.15 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хууль дүрмийг сурталчилах, хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр төрөл бүрийн ажил арга хэмжээг зохион байгуулан нийтэд | Гэмт хэрэг, зөрчлийн тоо их. | Гэмт хэргийн гаралт буурсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар Цагдаагийн хэсэг ГХУССЗ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сурталчилж, ***“замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулна”***. | | | | |
| **7** | СЗДҮАХ 2.16 | Бусдын эд хөрөнгийг залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд энэ чиглэлийн мэдлэг мэдээллийг олгох ажлыг зохион байгуулж ажиллана. | Иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг. | Гэмт хэргийн гаралт буурсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар Цагдаагийн хэсэг ГХУССЗ |
| **8** | СЗДҮАХ 2.14 | Хүрээлэн буй орчны гэмт хэргийг таслан зогсооно. | Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил их байна. | Гэмт хэрэг, зөрчлийн тоо эрс буурсан болон огт гараагүйгээр зогссон байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ИТХурал ЗДТГазар Цагдаа |
| **3.ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Тогтвортой эдийн засаг хөгжлийн тулгуур.** | | | | | | |
| **3.1 Хөдөө аж ахуйн бодлого** | | | | | | |
| **Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлнэ.** | | | | | | |
| **1** | АЗДҮАХ 3.1.5, СЗДҮАХ 3.2 | Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн тоог нэмэгдүүлж сумын иргэдийг хүнсний ногоогоор хангаж, бүх төрлийн хүнсний ногооны суулгац, үрсэлгээгээр орон нутгийн иргэдийг хангах бодлогыг хэрэгжүүлж ажиллана. | Иргэдийн эрэлт хэрэгцээ их байна. | Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар ТББайгууллага |
| **2** | СЗДҮАХ 3.3 | Төмс, хүнсний ногоо тариалж буй иргэдийн ногоог хадгалах зорилгоор стандартын шаардлага хангасан 100 тонны багтаамжтай зоорь барих | Иргэдийн хэрэгцээ шаардлага их байна. | Зоорь баригдсан байна. | Төслийн хөрөнгөөр | ЗДТГазар Төсөл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг эхлүүлнэ. | | | | |
| **3** | АЗДҮАХ 3.1.5, СЗДҮАХ 3.4 | Ногоочдын хоршоо, холбооны үйл ажиллагааг эрчимжүүлж дэмжин орон нутгийн иргэдийн тариалсан төмс, хүнсний ногоог зах зээлд борлуулах сүлжээг бий болгоно. | Иргэдийн хэрэгцээ шаардлага их байна. | Өрхийн орлого нэмэгдсэн байна. | Төсвийн болон, төслийн хөрөнгөөр | ЗДТГазар Төсөл ТББайгууллага |
| **4** | СЗДҮАХ 3.6 | Бэлчээрийн ургамлын бүтцийг сайжруулах чиглэлээр олон наст ургамал " ***ногоон тэжээл"***-тариалах иргэн, малчид, хоршоог бодлогоор дэмжиж ажиллана. | Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэдийн тулгамдсан асуудлын нэг. | Бодлогыг тодорхойлж дэмжиж ажилласан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ИТХурал ЗДТгазар |
| **5** | СЗДҮАХ 3.7 | Сумын өвс , тэжээлийн фонд бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Өвс тэжээлийн нөөцийн төрлийг нэмэгдүүлэх | Иргэн, ААНэгжийн оролцоотойгоор нөөцийг бүрдүүлсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **6** | АЗДҮАХ 3.1.5, СЗДҮАХ 3.8 | ***"Алтан намар", "Сэлэнгэд үйлдвэрлэв" , " Намрын ногоон өдрүүд"*** зэрэг уламжлал болгон зохион байгуулагддаг аймаг, улсын үзэсгэлэн худалдаанд ногоочид болон жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулж, бүтээгдэхүүний нэр | Ковид-19 цар тахлын улмаас зохион байгуулагдсан арга хэмжээнүүдэд үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг бүрэн хамруулж чадаагүй. | Холбогдох арга хэмжээг зохион байгуулж өргөн бүрэлдэхүүнээр оролцуулсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар ТББайгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төрлийг олшруулах замаар харилцан туршлага солилцуулах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. | | | | |
| **7** | СЗДҮАХ 3.9 | Мал эмнэлгийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналтыг сайжруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж "***Эрүүл малтай"*** сум болно. | Хувийн хэвшлийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай. | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар ТББайгууллага |
| **8** | СЗДҮАХ 3.11 | Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор сумандаа жишиг үржлийн нэгжийг цогцоор нь байгуулах ажлыг эхлүүлнэ. | Одоогоор үржлийн нэгжийн үйл ажиллагаа тогтмолжоогүй. | Үржлийн нэгжийг байгуулах ажлыг эхлүүлсэн байна. | Төслийн хөрөнгөөр | ЗДТГазар Төсөл |
| **9** | АЗДҮАХ 3.1.7, СЗДҮАХ 3.12 | Мах, сүүний чиглэлээр үхрийн цөм сүргийг бүрдүүлэх, малын үүлдэрлэг чанарыг голлон хөгжүүлэх үүднээс мах, сүүний чиглэлийн бухаар хангаж ажиллана. | Мал бүхий иргэдийн малд хээлтүүлэгч бух хүрэлцээгүй. | Мах, сүүний чиглэлийн бухаар хангасан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **10** | Алсын хараа-2050 8.3.18, ЗГҮАХ 3.3.8, МУХҮЧ 8.3.5, СЗДҮАХ 3.15 | ***"Мал угаалгын банн"***-ыг хөдөөгийн хэсгүүдэд барьж байгуулна. | Мал угаалгын банны хүрэлцээ хангамж муу. | Тодорхой хэсгүүдэд мал угаалгын банныг байгуулсан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **11** | СЗДҮАХ 3.16 | Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алсын бэлчээрт ***" худаг ус гаргах",*** зам даваа засан сайжруулах арга хэмжээг | Алсын бэлчээрт ашиглах худаг ус хангалтгүй. | Тодорхой хэсгүүдэд худаг усыг гаргасан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дэс дараатай хэрэгжүүлнэ. | | | | |
| **12** | АЗДҮАХ 3.1.7, СЗДҮАХ 3.17 | Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг уламжлалт мал аж ахуйтай хослуулан эрхлэхийг бодлогоор дэмжинэ. | Малын тоо толгойн өсөлтийг эрчимжсэн мал аж ахуй эрхлэх замаар бууруулах | Малын чанар, үүлдэр угсаа сайжирч эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **13** | СЗДҮАХ 3.18 | “Тариалангийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Малчид, тариаланчдын зөрчил ихтэй. | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар ААНэгжүүд |
| **14** | СЗДҮАХ 3.18 | Малчид, тариаланчдын зөвлөгөөнийг зохион байгуулна. | 2021 онд цар тахалтай холбоотойгоор хийгдээгүй. | Зөвлөгөөнийг хийсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **3.2 Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлого** | | | | | | |
| **Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй, үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжинэ.** | | | | | | |
| **1** | Алсын хараа-2050 2.3.5, 3.3.1, 3.3.21, ЗГҮАХ 2.5.14, МУХҮЧ 3.3.2, СЗДҮАХ 4.1 | Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж иргэдийнхээ жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг дэмжинэ. | Хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэлт хангалтгүй байсан. | Хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэж жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байна. | Төсвийн болон ААНэгжийн хөрөнгөөр | ЗДТГазар ААНэгж |
| **2** | СЗДҮАХ 4.4 | Худалдаа үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, боловсон хүчний чадавхийг сайжруулж үйлчилгээний соёл, стандарт мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалтанд хамруулж ур | Үйлчилгээний чанар, соёл, стандартыг дээшлүүлэх, боловсон хүчний ур чадвар, соёлыг дээшлүүлэх | Худалдаа үйлчилгээний чанар стандарт, боловсон хүчний чадавхи, соёл дээшилсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар ААНэгж |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | чадвар, соёлыг дээшлүүлнэ”. | шаардлагатай. | | | |
| **3** | Алсын хараа-2050, 2.3.7, 3.3.1, 3.3.15, ЗГҮАХ 2.5.14, МУХҮЧ 3.3.1, СЗДҮАХ 4.6 | ***“Сум бүрт нэг үйлдвэрлэл - үйлчилгээ”*** хөтөлбөрийн хүрээнд сумынхаа үйлдвэржилтийн бодлого зорилтыг шинээр тодорхойлж ,сумандаа иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан үйлдвэрлэл - үйлчилгээг бий болгоход иргэдтэй хамтарч ажиллана. | Гутал засвар, хими цэвэрлэгээ, хоёрдогч болон малын гаралтай түүхий эд боловсруулах, сүү боловсруулах үйлдвэрлэл үйлчилгээ шаардлагатай. | Шинэ төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгосон байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар ААНэгж |
| **4** | Алсын хараа-2050 3.3.9, ЗГҮАХ 2.5.14, МУХҮЧ 3.3.3, СЗДҮАХ 4.6 | Ногоочдын холбоог түшиглэн ***“Ногоо боловсруулах цех”***-ийг шинээр байгуулах замаар орон нутагтаа ажлын байрыг нэмэгдүүлнэ. | Иргэдийн эрэлт хэрэгцээ шаардлага. | Шинэ төрлийн үйлчилгээг бий болгосон байна. | Төслийн хөрөнгөөр | ЗДТГазар Төсөл |
| **3.3. Хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бодлого** | | | | | | |
| **Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| **1** | АЗДҮАХ 3.5.3, САХТЖҮЧ 8.1.5, СЗДҮАХ 1.3 | Ерөө сумын 2-р багийн Хужирынхаяа хэсгийн айл өрхийг цахилгаан, эрчим хүчээр хангах ажлыг гүйцэтгэнэ. | Гэрэл цахилгаанд холбогдоогүй. | Гэрэл цахилгаанаар хангагдсан байна. | ААНэгжийн хөрөнгөөр | ЗДТГазар ААНэгж |
| **2** | АЗДҮАХ 3.5.3, САХТЖҮЧ 8.1.5, СЗДҮАХ 1.5 | Шинээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын цахилгааны зураг төсвийг хийлгэх, мөн шинэ суурьшлын бүсийн | Уг газар нь цахилгаанд холбогдоогүй бөгөөд зарим хэсгийн айл өрхийн цахилгааны | Гэрэл цахилгаанаар хангагдсан байна. | Төсвийн болон ААНэгжийн хөрөнгөөр | ЗДТГазар ААНэгжүүд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | цахилгааны хүчдэлийг сайжруулж ажиллана. | хүчдэл муу. | | | |
| **3** | СЗДҮАХ 1.6 | Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь замуудыг үе шаттайгаар ***“хатуу хучилттай зам“*** болгоно. | Замын эвдрэл гэмтэл ихтэй. | Тодорхой хэсгүүдэд зам талбайг засаж сайжруулсан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **4** | СЗДҮАХ 1.9 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг засварлан, тодорхой хэсгүүдэд нэмж шинэ гэрэлтүүлэг тавина. | Гудамж талбайн гэрэлтүүлэг хангалтгүй. | Тодорхой хэсгүүдэд гэрэлтүүлгийг шинээр тавьж, засаж сайжруулсан байна. | Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **5** | СЗДҮАХ 1.14 | Сум, тосгоны тоглоомын талбайг стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомоор баяжуулан, хуучин талбайнуудыг засаж шинэчлэн, шинээр байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. | Тоглоомын талбайн хүрэлцээ муу, эвдэрч муудсан. | Орчин үеийн стандартад нийцсэн тоглоомын талбайг байгуулж зарим хэсгийн тоглоомын талбайг засаж сайжруулсан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **6** | АЗДҮАХ 3.5.18, СЗДҮАХ 1.17 | Бугант тосгоны Төв уурын зуухыг шинэчлэх, дулааны шугам хоолойг засварлах, өргөтгөл хийх ажлыг хийж гүйцэтгэнэ. | Төв уурын зуух, дулааны шугамын хоолой муудсан. | Засвар, шинэчлэл, өргөтгөлийн ажил хийгдсэн байна. | Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **7** | АЗДҮАХ 3.5.15, СЗДҮАХ 1.22 | Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, Гэрэлт гудамж, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын | Ногоон байгууламжийн тоо хэмжээ, тохижилтыг нэмэгдүүлэх | Тоо хэмжээ нэмэгдэж, тохижилт сайжирсан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг хийнэ. | | | | |
| **8** | Алсын хараа-2050 2.3.2, 2.3.11, ЗГҮАХ 2.5.8, МУХҮЧ 2.3.1, СЗДҮАХ 4.8 | Түр хамгаалах байрыг барина. | Түр хамгаалах байр шаардлагатай. | Байртай болсон байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **9** | АЗДҮАХ 3.5.8, 3.5.9 | Засаг даргын Тамгын газрын байрны зураг төсвийг хийлгэнэ. | Одоогийн үйл ажиллагаа явуулж буй байр олон жилийн насжилттай, өрөө тасалгааны багтаамж, хүрэлцээ муу. | Зураг төсвийг хийлгэсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **10** | | Ерөө сумын 1-р цэцэрлэгийн гадна тохижилтын ажлын хүрээнд хашаа хайсыг барина. | Шинэ баригдаж буй цэцэрлэгийн барилгын гадна тохижилт хийгдээгүй. | Орчны тохижилт сайжирсан байна. | Төсвийн хөрөнгөөр | Цэцэрлэг |
| **11** | СЗДҮАХ 2.11 | Ахмадын сувилал барина. | Ахмадын сувиллын зориулалтын барилга байгууламжгүй. | Шинэ ахмадын сувилал баригдсан байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **12** | МУХҮЧ-ийн 3.6.2, ЗГҮАХ-ийн 3.7.2 САХТЖҮЧ-ийн 3.5.1, СЗДҮАХ 1.26 | Айл өрхийн хаягжуулалтын ажлыг хийнэ. | Айл өрхийн хаягжуулалтыг шинэчлэх шаардлагатай. | Өрх бүр хаягийг шинэчилсэн байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| | | Гудамжны гэрлийн | Тусгай | Эвдрэл гэмтэл гарсан тухай бүрд засвар | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | СЗДҮАХ 1.9 | шонгийн засвар үйлчилгээг хийх зориулалттай тусгай зориулалтын тоног төхөөрөмж худалдан авах | зориулалтын өргөгч шаттай тээврийн хэрэгсэл байхгүй. | үйлчилгээг хийж гудамжны гэрлийн байнгын хэвийн асах боломж бүрдэж иргэдийн аюулгүй амьдрах нөхцөл хангагдана. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| 14 | | Төв зам дагуу /колонкоос гүүр хүртэлх/ гэрлийн шонгийн цахилгааны утсыг агаараар татаж, шатсан гэрлийн толгой солих засварын ажлыг хийж гүйцэтгэнэ. | Уг чиглэлийн гэрэл нь газар доогуур явсан кабель тасарсан шалтгаанаар асахгүй байгаа. | Сумын төвийн өнгө үзэмж нэмэгдэж, иргэд, хүүхэд багачуудын аюулгүй орчинд амьдрах боломж бүрдэнэ. | Өөрийн хөрөнгөөр | Төгөлдөр Ерөө ОНӨАТҮГазар |
| 15 | | ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэлтэй Универсал тракторыг засварлаж хэвийн ажиллагааг хангаж ажиллана. | Эвдрэл гэмтлийн улмаас ажиллахгүй байгаа. | Сумын нэгдсэн хогийн цэгийн хогийг тухай бүр нь түрж стандартын дагуу булшлах ажил хийгдэх боломжтой болно. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| 16 | | Бугант тосгонд бетонон хучилттай авто зогсоол, явган хүний замыг барих ажлыг гүйцэтгэнэ. | Иргэдийн хэрэгцээ шаардлагаар | Тосгоны өнгө үзэмж, тохижилт сайжирч иргэд ая тухтай, таатай орчинд амьдрах боломж бүрдэнэ. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| 17 | | Байгаль орчны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахаар туулах чадвар сайтай тээврийн хэрэгслээр | Албан ажлын хэрэгцээ шаардлагаар | Ажлын бүтээмж сайжирч хүрээлэн буй орчны гэмт хэрэг, зөрчил буурна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хангана. | | | | |
| **18** | | Иргэний танхим, хурлын зааланд сургалтын тоног төхөөрөмж худалдан авах | Албан ажлын хэрэгцээ шаардлагаар | Иргэдэд мэдээлэл сурталчилгааны ажил хийх орчин бүрдэнэ. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **19** | | 2023 оны хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн зардал | Албан ажлын хэрэгцээ шаардлагаар | Хөрөнгө оруулалтын ажлын зөв төлөвлөлт, цаг хугацаандаа хэрэгжих боломж бүрдсэн байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **20** | | Сүү, сүүн бүтээгдэхүүний тоног төхөөрөмж худалдан авах | Малчин, мал бүхий иргэдийн санал санаачилгаар | Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл үйлчилгээ бий болсон байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **21** | | Бугант тосгон 2 км хайрган хучилттай зам байгуулах ажил | Иргэдийн хэрэгцээ шаардлагаар | Замын байгууламжийг нэмэгдүүлж сайжруулсан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **22** | | Худалдааны гудамж байгуулах | Иргэдийн хэрэгцээ шаардлагаар | Сум, орон нутгийн өнгө үзэмж, тохижилт үйлчилгээ сайжирсан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **23** | | Бугант тосгоны ЕБСургуулийн үдийн цайны газрын агааржуулалтын хоолойг засварлах | Албан ажлын хэрэгцээ шаардлагаар | Хүүхдүүд эрүүл ахуйн шаардлага хангасан, тав тухтай орчинд хоол хүнсний үйлчилгээг авах боломж бүрдсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | Бугант ЕБСургууль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **24** | | Ерөө Цагдаагийн кубоны байрыг халаалтын шугамд холбох | Албан ажлын хэрэгцээ шаардлагаар | Албан хаагчид дулаан, тав тухтай орчинд ажил, үйлчилгээ явуулах боломж бүрдсэн байна. | Төсвийн хөрөнгөөр | Цагдаа |
| **25** | | Албан байгууллага, ААНэгжүүд, айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ. | Одоогоор уг ажил нь хийгдээгүй байгаа. | Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байна. | Төсвийн хөрөнгөөр | ЗДТГазар |
| **3.4 Ногоон хөгжил, байгаль орчны бодлого** | | | | | | |
| **Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| **1** | СЗДҮАХ 5.3 | Ойн нөөцийг хамгаалах, үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээх мэргэжлийн байгууллагуудын менежментийг сайжруулах, жил бүр өөрсдийнх нь хөрөнгөөр ойжуулалтын ажлыг хийлгэж хүлээн авна. | Ойжуулалтын ажил шаардлагатай. | Ойжуулалтын ажлыг нэмэгдүүлсэн байна. | ААНэгж, төслийн хөрөнгөөр | Төсөл ААНэгж |
| **2** | СЗДҮАХ 5.4 | Сумандаа ***“ойн цэвэрлэгээ”***-ний ажлыг зохион байгуулж ажил хайгч иргэдийг түр ажлын байраар хангахын зэрэгцээ ахмад настан болон зорилтот бүлгийн өрхийг хямд үнэтэй түлшний модоор хангаж ажиллана. | Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хийх | Түр ажлын байр бий болж ойн цэвэрлэгээ хийгдсэн байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар |
| **3** | СЗДҮАХ 5.7 | Сум ,тосгоны нэгдсэн хогийн цэгийн хог хаягдлыг цэгцэлж байнгын | Шаардлагатай цаг хугацаанд | Ажлын байр бий болж орчны тохижилт сайжирч | Төсвийн болон ААНэгжийн | ЗДТГазар ААНэгж |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | харуул хамгаалалттай болгон камер суурилуулж хяналтыг сайжруулж ажиллана . | түрж цэгцлэх | байгаль орчныг хамгаална. | хөрөнгөөр | |
| **4** | СЗДҮАХ 5.8 | ***“Ногоон Ерөө”*** хөдөлгөөнийг эрчимжүүлж , өрх бүрийг ногоон байгууламжтай болгох замаар сумын төвийн болон нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | Ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлж орчны тохижилтыг сайжруулах | Сум, орон нутгийн тохижилт, өнгөр үзэмж сайжирсан байна. | ОНХСангийн хөрөнгөөр | ЗДТГазар ТББайгууллага |
| **5** | Алсын хараа-2050 6.2.10, ЗГҮАХ 5.1.8, СЗДҮАХ 5.9 | Байгаль хамгаалах, байгалийг нөхөн сэргээх ажил эрхэлж байгаа иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжиж уул уурхайн эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх, бичил уурхай болон ойн цэвэрлэгээг зохион байгуулан орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, өрхийн орлогыг дээшлүүлэх аливаа үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллана. | Нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай их. | Эвдрэлд орсон талбайн хэмжээ багасч, нөхөн сэргээсэн талбайн хэмжээ нэмэгдсэн байна. | Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр | Аймгийн БОАЖГазар ЗДТГазар |
| **6** | СЗДҮАХ 5.10 | Ерөө гол түүний цутгал голууд, Ерөө, Бугант голыг цэвэр урсгах зорилгоор болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх санал санаачилга гарган | Гол ус ихээхэн бохирдсон. | Усны бохирдолгүй болж иргэд эрүүл орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. | Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр | Аймгийн БОАЖГазар ЗДТГазар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллаж буй иргэн ААН, ТББ-ын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана. | | | | |
| **7** | АЗДҮАХ 3.2.4, СЗДҮАХ 5.12 | Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажилд ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулж , тэдэнтэй хамтран ажиллах гэрээг байгуулан дүгнэж хамтран ажиллана. | ААНэгжийн санал санаачилга дутмаг | Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ААНэгжийн хариуцлага сайжирсан байна. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар ААНэгж |
| **8** | САХТЖҮЧ 2.5.2 | Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглах санал санаачлагыг дэмжин, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллах хүрээнд айл өрх, албан байгууллага, цэцэрлэгийн хүүхдүүд, ЕБСургуулийн сурагчдад “Хог хаягдлын тухай” хууль тогтоомжийн талаарх сургалт зохион байгуулж ажиллана. | Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, хүрээлэн буй орчны бохирдлын талаар иргэдийн ойлголт дутмаг. | Хог хаягдлын талаарх иргэдийн мэдлэг дээшилж, эх үүсвэр дээр хог хаягдал ангилан ялгагдаж, хог хаягдлын хэмжээ буурч, хөрсний бохирдол багасч эрүүл орчинд амьдрах боломж бүрдэнэ. | Хөрөнгө шаардагдахгүй. | ЗДТГазар Төгөлдөр Ерөө ОНӨАТҮГазар |